

Дулааны эрчим хүчээр хангах техникийн
нөхцөл олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд шинээр барилга, объект холбох техникийн нөхцөл олгохдоо эх үүсвэрийн хүчин чадал, Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, дулааны сүлжээний горим ажиллагааны байдал, техник технологийн шинэчлэлтэй уялдуулан дулаанд холбох техникийн нөхцөл олгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Иргэн, хуулийн этгээдээс Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд шинээр барьсан болон шинэчлэн, өргөтгөсөн барилга объектоо холбуулахад хангавал зохих техникийн цогц шаардлагыг “Техникийн нөхцөл” гэнэ.

1.3. Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах, зураг төслийн ажлын гүйцэтгэл, барилга угсралтын ажилд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахад энэ журмаар олгогдсон техникийн нөхцлийг үндэслэл болгоно.

Хоёр. Техникийн нөхцөл олгох үндэслэл

2.1. Иргэн, хуулийн этгээд нь шинээр барилга байгууламж барих, хуучин барилга байгууламжаа нурааж шинэчлэн өргөтгөх, ачааллыг өөрчлөх болон дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээ, халаалтын системийн техникийн шийдлийг өөрчлөх технологийн шинэчлэл хийх тухай бүрт техникийн нөхцөл олгоно.

2.2. Техникийн нөхцөл хүсэж буй иргэн, хуулийн этгээд нь дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

2.2.1. Дулааны эрчим хүчний тооцоот ачааллыг тодорхойлж, техникийн нөхцөл хүссэн албан бичиг, өргөдөл;

2.2.2. Улаанбаатар хотын Ерөнхий архитекторын баталсан барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар;

2.2.3. Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газраас сүүлийн 2 жилд батлагдсан эскиз зураг ерөнхий төлөвлөгөөг бүрдүүлсэн байна.

2.3. Горим тооцооны хэсэг нь техникийн нөхцлийн судалгааг хийж, тооцоо, дүгнэлт гаргах ба дүгнэлтийг Техникийн нөхцөл олгох комиссын хурлаар хэлэлцүүлж, техникийн нөхцөл олгох, эсэхийг шийдвэрлэнэ.

2.4. Горим тооцооны хэсгийн инженерүүд, дулааны шугам сүлжээний гидравлик горимын тооцооны дүн, эх үүсвэрийн хүчин чадал, төв магистраль болон салаа шугамуудын нэвтрүүлэх чадварт тулгуурлан, жил бүр дулааны чадлын

нөөцийг тодорхойлон гаргаж, компанийн Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулсан байна.

Гурав. Техникийн нөхцөл олголт

3.1. Барилга байгууламжийг дулаанд холбох техникийн нөхцөл олгохдоо, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тушаалаар батлагдсан “Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам”, Засгийн Газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах дүрэм”, Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 8 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд мөрдөх холболтын журам”, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг мөрдөж ажиллана.

3.2. Техникийн нөхцөл олгох комисс нь Улаанбаатар хотын Ерөнхий архитекторын баталсан барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан зураг төслийг үндэслэл болгон 1 Гкал/цаг хүртэл ачаалал бүхий барилгад техникийн нөхцөл олгоно.

3.3. Горим тооцооны хэсэг нь “Горим тооцооны хэсгийн ажиллах журам”-ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

3.4. Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийн дулааны ачаалал зураг төслийн явцад анхны авсан техникийн нөхцөлд заасан хүчин чадлаас 10 хувиас дээш хэмжээгээр нэмэгдсэн тохиолдолд дахин техникийн нөхцөл авна.

3.5. Үндсэн барилгын дотор халаалтын системээс шууд холболт хийж, дулааны эрчим хүчээр хангагдахаар төлөвлөсөн, давхарын нэмэлт болон хажуу тийш сунгасан 300 м² хүртэл талбай бүхий хэмжээтэй өргөтгөлийн хэсгийг, тус компанид ажилладаг комиссын гишүүд хэлэлцэн хурлын тэмдэглэл хөтлөж, дулааны эрчим хүч худалдах худалдан авах гэрээний эх үүсвэрт өөрчлөлт оруулж дулааны эрчим хүчээр хангаж болно.

3.6. Техникийн нөхцөл хүсэгч нь бусдын өмчлөлийн шугам, тоног төхөөрөмжөөр дамжуулан дулаан авах бол тухайн шугам, тоноглолын өмчлөгчтэй зөвшилцсөн байна.

3.7. Гэр хорооллын дахин төлөвлөлт хийсэн байршилд иргэн, хуулийн этгээд ганц нэгээрээ техникийн нөхцөл хүссэн тохиолдолд ерөнхий төлөвлөгөөний барилгуудтай уялдуулан нэгдсэн байдлаар шийдвэрлэнэ.

Дөрөв. Техникийн нөхцлийн агуулга

4.1. Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөлд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

4.1.1. Дулааны тооцоот дээд ачаалал;

4.1.2. Холболтын цэг; (Магистраль шугам, дулааны худаг, үл хөдлөх тулгуур) уг цэг дээрх түрэлт, шугамын статик болон буцах шугамын даралт, тооцоот температур

4.1.3. Төвлөрсөн дулаан хангамжид холбох зураг төсөл хийх техникийн даалгавар;

4.1.4. Дулааны тоноглолын иж бүрдэл, техник технологийн шаардлага; /хэд хэдэн объектод хамтатган техникийн нөхцөл олгосон тохиолдолд тэдгээрийг бүхэлд нь хамарсан нэгдсэн шугам сүлжээ, дулааны төв барих тухай дүгнэлт/

4.1.5. Дулааны шугам, худаг, зангилгаа бусад тоног төхөөрөмжүүдэд өргөтгөл хийх эсэх;

4.1.6. Дулааны хэмжих хэрэгсэл, чанарын үзүүлэлтүүдийг тогтворжуулах төхөөрөмж;

4.1.7. Барилгад тавигдах тусгай шаардлага;

4.1.8. Барилгад ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлага;

4.1.9. Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаа;

4.1.10. Холбогдох тогтоол, хурлын шийдвэрийн заалтууд байна.

Тав. Бусад зүйл

5.1. Иргэн, хуулийн этгээд нь дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл авсан тохиолдолд суурь хураамж болох 150000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг Улаанбаатар дулааны сүлжээ ХК-ийн Худалдаа хөгжлийн банкны 406005907 тоот дансанд тушаасан байна.

5.2. Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцлийн дагуу иргэн, хуулийн этгээдийн барьж байгуулах инженерийн байгууламж нь тохижуулсан зам, талбай, ногоон байгууламжийг нэвтрэн гарах бол тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг бүрэн хариуцна.

5.3. Төвлөрсөн дулаан хангамжийн системд техникийн нөхцлийн дагуу иргэн, хуулийн этгээдийн тухайн объектыг холбоход халаалтын цогц төхөөрөмжийн хүчин чадал, салбар шугам сүлжээг зайлшгүй өргөтгөх шаардлага гарсан үед зардлыг иргэн хуулийн этгээд бүрэн хариуцна.

5.4. Дулааны хэрэглээгээ санаатай эсвэл санамсаргүйгээр буруу тодорхойлон бодит хэрэглээгээ 10 хувиас дээш хэмжээгээр өсгөж болон бууруулан техникийн нөхцөл авсан тохиолдолд олгосон техникийн нөхцлийг хүчингүй болгоно.

5.5. Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаа 2 жил байх бөгөөд хугацаа дууссан тохиолдолд 1 удаа 1 жилээр сунгаж болно.

5.6. Хугацаа нь дууссан техникийн нөхцлөөр зураг төсөл боловсруулж, барилга байгууламж барихыг хориглоно.

5.7. Иргэн, хуулийн этгээд техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтийг хангагч байгууллагад гаргана.

5.8. Техникийн нөхцөлтэй холбоотой гарсан маргааныг хууль, дүрэм, журмын дагуу шийднэ.

5.9. Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон техникийн нөхцөл нь тухайн зөвшөөрөл хүссэн барилга объектыг төвлөрсөн дулаан хангамжид холбох үндэслэл болно.

Горим тооцооны хэсгийн ажиллах журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Иргэн, хуулийн этгээдийн барилга объектоо төвлөрсөн дулаан хангамжинд холбуулах хүсэлтийг судалж, гидравлик тооцоо хийж дүгнэлт гаргах, горим тооцооны хэсгийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Горим тооцооны хэсэг нь 1 Гкал/цаг хүртэл ачаалалтай барилга байгууламжийн гидравлик тооцооны дүгнэлтийг компанийн “Техникийн нөхцөл олгох комисс”-ын хуралд, 1 Гкал/цагаас дээш ачаалалтай барилга байгууламжийн гидравлик тооцооны дүгнэлтийг Эрчим хүчний яамны “Техникийн нөхцөл олгох комисс”-ын хуралд танилцуулна.

Хоёр. Тооцоо судалгаа хийж, дүгнэлт гаргах дараалал

2.1. Тооцоо судалгааны хэсэг нь дулааны шугам сүлжээний гидравлик горимын тооцооны дүн, эх үүсвэрийн хүчин чадал, төв магистраль болон салаа шугамуудын нэвтрүүлэх чадварт тулгуурлан, жил бүр дулааны чадлын нөөцийг тодорхойлон гаргаж, компанийн Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулна.

2.2. Техникийн нөхцөл хариуцсан инженер техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, албан бичгийг хүлээж авч танилцаад материал нь бүрдсэн хэрэглэгчийн жагсаалтыг гаргаж, байршил барилга байгууламжийг тодорхойлсон схем зургийн хамт “Горим тооцооны хэсэг”-т хүлээлгэж өгнө.

2.3. Техникийн нөхцөл хүссэн материалын бүрдэл дутуу болон техникийн өгөгдөл нь ойлгомжгүй шаардлага хангахгүй хүсэлт ирүүлсэн, иргэд хуулийн этгээдэд техникийн нөхцөл хариуцсан инженер албан бичгээр мэдэгдэж хариуг хүргүүлнэ.

2.4. “Горим тооцооны хэсэг”-ийн инженерүүд материал хүлээж авснаас хойш ажлын 7-10 хоногийн дотор тооцоо судалгааг хийж дүгнэлт гаргана.

2.5. Гидравлик тооцоог хийж, гарсан дүгнэлтийг батлагдсан тооцооны хуудсанд бичиж гарын үсгээр баталгаажуулан схем зураг болон бусад материалын хамт “Техникийн нөхцөл олгох комисс”-ын нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө. Шаардлагатай тохиолдолд Техникийн нөхцөл олгох комиссын хуралд орж мэдээлэл хийнэ.

2.6. Тооцооны дүнгээр эх үүсвэрийн болон шугам тоноглолын хүчин чадал хүрэлцэхгүй, тухайн орчинд дулаан хангамжийн өнөөгийн байдал нь хүндрэлтэй, халаалтын гомдол ихтэй байдаг зэргээс шалтгаалан техникийн нөхцөл олгоогүй

тохиолдолд энэ тухай албан бичгээр хариу өгнө. Техникийн нөхцөл олгоогүй шалтгаан болон цаашид авах арга хэмжээний талаар тайлбар хийж болно.

Гурав. Бусад

3.1. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөж ажиллана.

3.2. Техникийн нөхцөл авсан хэрэглэгчдийн барилга объект нь дулааны сүлжээнд холбогдсон тохиолдолд бүртгэл хийж байх ажлыг Инженерийн албаны холболтын инженерүүд гүйцэтгэнэ.